



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 4/06

Сүхбаатар сум

Эрүүл мэндийн газрын дэргэдэх
“Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны
зөвлөн туслах баг” байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам батлах тухай” А/503 тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын хүрээнд мэргэжил, аргазүйн удирдлагаар ханган, хяналт тавин ажиллах хүрээнд зөвлөн туслах чиг үүрэг бүхий зөвлөх багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвлөх багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн багийн ахлагч Эмнэлгийн тусламж үйлчилгээний даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Азжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (У.Ууган-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ОД

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 02 сарын 11 өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт


“Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны
зөвлөх баг”-ийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: С.Азжаргал (Эмнэлгийн тусламж үйлчилгээний даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхцэцэг (Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн
мэргэжилтэн)

Гишүүд:
П.Сэлэнгэ (Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга)
Ц.Дарьсүрэн (Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн
мэргэжилтэн)
Э.Мөнхсүлд (Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн
мэргэжилтэн)
Т.Мягмарцэнд (Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн
мэргэжилтэн)
Д.Бурмаа (Тархвар судлаач)

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨХ БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ



НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Журмын зорилго нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүн хүртээмжийг сайжруулах, зөвлөн туслах чиг үүргийг гүйцэтгэх эрүүл мэндийн газрын дэргэдэх зөвлөх багийн үйл ажиллагааг зохицуулан, ажиллах зарчмыг тодорхойлоход оршино.
2. Зөвлөх баг нь бусад улс орон, аймгийн тэргүүн туршлага, технологийг судалж, өөрийн орон нутагт нутагшуулан нэвтрүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадваржуулахад чиглэсэн санал, санаачилгыг эрүүл мэндийн газрын удирдлагад танилцуулж хэрэгжүүлнэ.
3. Зөвлөх багийн гишүүд нь эрүүл мэндийн байгууллагын баримт бичгийн бүрдүүлэлтэд зөвлөгөө өгөх, цахимаар баримт бичгийг хүлээн авч, хяналт тавих үүрэгтэй бөгөөд хуулийн байгууллагад зөвлөлийн гишүүний нэрийн өмнөөс шинжээчээр ажиллаж, дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй, ашгийн төлөө ямар нэгэн үйл ажиллагаанд оролцохгүй болно.

ХОЁР. Зөвлөх багийн удирдлага, зохион байгуулалт

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх зөвлөх багийн ажиллах чиглэлийг багийн гишүүдтэй, эрүүл мэндийн газрын удирдлага зөвшилцөн тогтооно.
2. Зөвлөх багийн гишүүд нь эрүүл мэндийн удирдлага, үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмч, тархвар судлал, сувилахуй, хүний нөөцийн чиглэлээр мэргэшсэн байна.
3. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой хүндрэл, бэрхшээл тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай гэж үзвэл эрүүл мэндийн газрын даргад танилцуулсан байна.
4. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангах чиглэлээр хариуцсан мэргэжилтнийг холбож ажиллах
5. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад явын хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, зөвлөмж өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, эрүүл мэндийн газрын даргад танилцуулсан байна.